Улсын нэгдсэн бүртгэлийн
2011 оны 03 дугаар сарын 15-ны
Өдрийн 3228 дугаарт бүртгэв.
Монгол Улсын Хууль зүйн яам

# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД, ЗАМ ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

## ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

/Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох журам/

2011 оны 03 дугаар сарын 07 -ны өдөр

Дугаар А-63/67

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын дагуу автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд түүнээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын алба /Б.Болдбаатар/, Агаарын чанарын мэргэжлийн алба /С.Энхтүвшин/-нд тус тус үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД
Л.ГАНСҮХ

ЗАМ ТЭЭВЭР, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД
Х.БАТТУЛГА

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын
2011 оны А/63/67 дугаар хамтарсан
тушаалын хавсралт

# АВТОТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ ХЭРЭГСЛЭЭС ЯЛГАРАХ НҮҮРСХҮЧЛИЙН ХИЙН ХЭМЖЭЭ, ХӨДӨЛГҮҮРИЙН БАГТААМЖААС ХАМААРУУЛАН АНГИЛАЛ ТОГТООХ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг түүнээс ялгаран гарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилж, агаарын бохирдлын төлбөрийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох үйл ажиллагааг "Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын алба" улсын хэмжээнд зохион байгуулна.

1.3. Тээврийн хэрэгслийн оношлогоо, хяналт зохицуулалтын алба нь "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хуулийн 7.3-т заасны дагуу тухайн автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийсний үндсэн дээр ногдох төлбөрт тохирох ангилалыг тогтоон Автотээврийн хэрэгслийн гэрчилгээнд тэмдэглэл хийнэ.

1.4. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч нь "Агаарын бохирдлын төлбөрийн тухай" хуулийн 7.3-т заасан ангилалын дагуу агаарын бохирдлын төлбөрийг холбогдох татварын албанд мөн хуулийн 9.3-т заасан хугацаанд багтаан төлнө.

## Хоёр. Төлбөр тогтоох үйл ажиллагаа

2.1. Агаарын бохирдлын төлбөрийн хэмжээг автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан дараахь байдлаар тогтооно:

| Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн ангилал | Бензин хөдөлгүүртэй | | Дизель хөдөлгүүртэй | Жилд ногдуулах төлбөр (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|
| | CO2 хийн ялгарал (г/км) | CO2 (%) | Хөдөлгүүрийн багтаамж (см3) | |
| А | 121-180 | 5.5-8.0 | 1500 хүртэл | 1800 |
| Б | 181-250 | 8.1-10.5 | 1501-2500 | 2100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| В | 251-350 | 10.6 -12.0 | 2501-3500 | 3500 |
| Г | 351-500 | 12.1-13.5 | 3501-4500 | 5000 |
| Д | 501-750 | 13.6 -14.5 | 4501-5500 | 7500 |
| Е | 751-ээс дээш | 14.6-ээс дээш | 5501-ээс дээш | 9500 |

2.2. Дараахь тохиолдолд автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан дахин ангилал тогтоолгоно:

а/ ажил, үйлчилгээний шаардлагын дагуу эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэлийн хөдөлгүүр болон түүний эд ангид нэмэлт, өөрчлөлт хийгдсэн бол;

б/ хөдөлгүүрийг сольсон бол;

**Гурав. Бусад**

3.1. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоохтой холбогдсон маргааныг Агаарын чанарын мэргэжлийн алба хүлээн авч дүгнэлт гаргах бөгөөд уг дүгнэлтийг үндэслэн харъяалах мэргэжлийн хяналтын байгууллага шийдвэрлэнэ.

------оOо------